

Эйл ажиллагааны шуурхай биш байдал хилийн анги салбарын удирдлагуудад хэлээлт бий болгох байдал тэгш болно.

3. Бүх төрлийн хангалт, төлний дотор албаны хангалтын тогтвортой тасралтгүй байдлыг хангах талаар нэгдмэл тогтсон системтэй болж, оператив-тактикийн удирдлагын төлсвөлс хамааралтай хангалт тэйчилгээний хэрэлцээгтэй байдал арилж анги салбарын тэйл ажиллагааг хил хамгаалалтыг зохион байгуулах нндсэн нргээс нь хндийрлж, цэргийн ндр тутамын сургалт, бэлэн байдлыг эрхэмлэх мэргэжлийн удирдлагын тэйл ажиллагаа алдагдахтэй улсын хил хамгаалалтын найдвартай байдлыг хангахад чиглэгдэнэ.

Хил хамгаалах байгууллагын цэргийн мэргэжлийн удирдлагыг боловсронгуй болгох хэрэнд дэвшлсэн асуудлыг цогцоор шийдвэрлэснээр хил хамгаалах байгуулаллагын эрх зйн, зохион байгуулалтын, удирдлагын, бүтцийн, мэргэжлийн, албаны болон ахуй хангалтын орчин бүрдэж, дэвшлсэн зорилтууд нндсэндээ шийдвэрлэгдэж, тэйл ажиллагаа нь тавигдаж буй шаардлагын шинэ төвшинд хрч улсын хил хамгаалалтыг мэргэшсэн удирдлагаар ил ндр днтэй хамгаалах арга болон төлөлших юм.

*ХСИС-ийн Хууль сахиулахын удирдлагын
академийн 821 дгээр дамжааны суралцагч,
хошууч Я.Гантмөр*

ХИЛИЙН АЮУЛГЭЙ БАЙДАЛД НӨЛӨЛЖ БУЙ ДОТООДЫН ХЭЧИН ЗӨЙЛС, ТӨНД ХИЙХ ШИНЖИЛГЭЭ

Хураангуй. Хилийн аюулгтэй байдал нь тодорхой орон зай дахь нндэсний ашиг сонирхлын аюулгтэй байдлаар голчлон тодорхойлогдож, аюулгтэй байдлын бусад бүрэлдэхүнд шууд нөлөөлж байдаг. Хилийн аюулгтэй байдлыг хангах дотоод таатай нхцл бүрдлэх нь улс, нийгмийн хгжил хил орчмын нутагт давуутай байж, энд оршин суугчдын материалын болон оюун санааны эрэлт хэрэгцээ бололцооны дээд хэмжээгээр хангагдсан, нндэстэн, ястны бат бэх нэгдэлтэй байдал, аюулгтэй орчин бүрэлдэж бий болсон нхцлийг хэлж болно.

Төлхөр г. Улсын хил, хилийн аюулгтэй байдал, хил орчмын нутаг дэвсгэр, дотоод гадаад хчин зйл.

Ндэсний аюулгтэй байдал нь олон элементийг агуулдаг бүртд хилийн аюулгтэй байдал бол нндэсний аюулгтэй байдлын уламжлалт нэг чухал элемент юм. Олон улсад хилийн орон зайд төр, нийгэм,

иргэний амин чухал эрх ашиг хамгаалагдсан байх нөхцлийг хилийн аюулгүй байдал гэж хэлдэг байна.

Харин Монгол Улсад нэгдэсний аюулгүй байдлын нэг зэл баримтлалын бэрэлдэхүүн хэсэгт “хилийн аюулгүй байдал” гэсэн нэг нөхцөлбэр байхгүй ч төрийн агуулга нь Монгол Улсын оршин тогтнохын аюулгүй байдлын хүрээнд хил хязгаарын халдашгүй байдал байдал гэсэн агуулгаар багтаж байгаа юм. Тиймээс энэхүү нэг зэл баримтлалын агуулгад шууд биш ч гэсэн шууд бусаар хилийн аюулгүй байдлыг тусгасан хэмээн үзэж штэй.

Хилийн аюулгүй байдал нь тодорхой орон зай дахь нэгдэсний ашиг сонирхлын аюулгүй байдлаар голчлон тодорхойлогдож, аюулгүй байдлын бусад бэрэлдэхүүнд шууд нөлөөлж байдаг.

Улсын хилийн аюулгүй байдалд нөлөөлж болох хүчин зүйлийг эх сурвалж, цаг хугацаа, шинж чанар, учруулах магадлаар нь **дотоод, гадаад** гэж хуваан үзэж болох ба хилийн орон зайд тус, нийгэм, иргэний амин чухал эрх ашигт аюул учруулж байгаа нөхцөл болон хүчин зүйлсдийн нийлбэр цогц юм. Хилийн аюулгүй байдлыг хангах **дотоод таатай** нөхцөл бэрдүүлэх нь улс, нийгмийн хөгжил хил орчмын нутагт давуутай байж, энд оршин суугчдын материалын болон оюун санааны эрэлт хэрэгцээ бололцооны дээд хэмжээгээр хангагдсан, **нэгдэсэн**, ястны бат бэх нэгдэлтэй байдал, аюулгүй орчин бэрэлдэж бий болсон нөхцлийг хэлж болно.

Иймд хилийн аюулгүй байдалд нөлөөлж буй зарим дотоод хүчин зүйлийн талаар төрийн саналаа илэрхийлэх гэсэн юм. Нэгд:

- Хил орчмын орон нутгийн хөгжлийн хоцрогдол;
- Хил орчмын нутаг дэвсгэр дэх эрхийн нөхцөл байдал;
- Хилийн бус, зурваст явагдах ажил үйлдвэрлэл;
- Хилийн болон хил орчмын дэглэмийн зөрчил;

Хилийн аюулгүй байдлыг хангахад хил орчмын орон нутгийн хөгжил, төнд иргэдийн суурьшил чухал нөлөө үзүүлдэг.

Хөгжлийн байршлыг төвийн, завсарын, хилийн гэсэн гурван бэсэд хувааж үзвэл Монгол Улсын нийгэм эдийн засгийн хөгжил нь ХХ зуунд хилийн бэсэд хүрч хөгжих бололцоогүй байснаас нөөдөр хил орчмын хөгжил хоцрогдож хил хязгаарын ард иргэд төвийн бус рүү нөөдэллэх. төвлөрсөн газар бараадах их нөөдэл явагдаж байгаа нь Монгол Улсын хязгаар нутаг эзэнгүйдэх аюул нөөрлөөд байна. Төхөн хугацаанд зөвхөн улсын хил болсон газар нутгийн хязгаарыг л сайн манаж хамгаалж байвал бүх юм болох, төрийг зөвхөн хил хамгаалдаг цэргээр гүйцэтгүүлбэл бүх зорилт хангагдах мэтээр ойлгож байснаас

хилийн орон зайн хөгжлийн асуудлууд орхигдож ирсэн гэж дүгнэж байна. Үүнээс үндэн улс нийгмийн хөгжилд тэргүүн хэмжээнд анхаарах ёстой хил орчмын хөгжил хоцрогдоход хүрсэн.

Ийм оновчтой бус хөгжлийн тогтолцооноос үндэн хилийн орон зай эзэнлүүлэх нь хилийн аюулгүй байдалд нөлүүлж буй хамгийн эмзэг асуудал болоод байгаа тдийгүй хязгаар нутгаас төвийн бүс рүү чиглэсэн шилжилт хэт төвлөлийг бий болгож, энэ нь эргээд **дотоодын аюулгүй байдалд** сөрөг нөлүүлж байгааг бид төвлөлий харж болно. Тухайлбал, манай улсын төв хэсэг. Улаанбаатар хотын ойролцоо бэлчээрийн даац хэтрэх, экологийн тэнцвэрт байдал алдагдах зэрэг олон сөрөг үр дагаврыг бий болгож байна.

Дээрх судалгаанаас үзэхэд эдийн засгийн макро бүсээс шилжин явж байгаа хэмжээний үндсэн шалтгаан нь ажил эрхлэх, зах зээлд ойртох, хөгжсөдийнхээ ирээдүйг бодох, боловсрол эзэмших, нхцлүү сайжруулах зэрэг асуудал юм. Зүвхн Увс аймгаас нэг жил (2015 он)-ийн дотор 641 үрх. 3615 хүн Төвийн бүс рүү шилжиж ирсэн нь нэг сумын хүн амтай тэнцэх тооны хүн шилжин иржээ. Үндрийн байдлаар Монгол Улсын нийт хүн ам 3 саяд хүрч, хдүүнүүс хот руу чиглэсэн хүн амын шилжилт хдүүлгүний нөлүүлж хотжилтын төвшин 67 хувьд хүрлээ. Нийслэл, бүсийн тулгуур төв, аймгийн төв, сумын төв зэрэг хот, суурин газруудад манай улсын нийт хүн амын 76 хувь нь амьдарч байна. Зүвхн нийслэл Улаанбаатар хотод улсын нийт хүн амын 44 хувь нь төвлөрч, аж ахуйн нэгж, байгууллагуудын 70 орчим хувь нь байршиж, дотоодын нийт бтээгдэхүүний 60 гаруй хувийг үйлдвэрлэж байгаа юм. Улсын хил хамгаалах шийдвэр гаргахдаа хил орчмын нутаг дэвсгэрийн эрүүгийн нхцлү байдлыг харгалзах нь үнүүд хил хамгаалах байгууллагын анхаарлын төвд байсаар байна. Ер нь аливаа хууль бус ажиллагаа, хил орчмын нутагт үүсч байгаа эрүүгийн гэмт хэрэг нь бусад гэмт хэргээс ялгагдах онцлогтой байдаг.

Улсын хилийн зөрчилтэй холбогдсон гэмт хэргийн байдлаас харахад цэрэг-улс төрийн шинжтэй үйлдэл бараг гараагүй бүгдүд ихэвчлэн нийгмийн хангамж, эдийн засаг, ахуй хэрэгцээний шинжтэй хэлбэр гол байрыг эзэлж байна. Урьд үмнү гарч байсан хилийн зөрчил ахуйн шинжтэй. төрч тэнүүлчилсэн буюу хил давсан малаа авах зорилгоор улсын хил зөрчдөг байсан бол одоо зохион байгуулалттай гэмт хэргийн бүлэглэлүүдийн үйл ажиллагаа болж хувирсан.

Улсын хил зөрчигчид хууль бусаар хил зөрчин гэмт хэрэг үйлдэн, үүнээс зайлсхийхийн тулд зэвсэг хэрэглэх явдал цүүн биш гарав. Энэ нь улсын хилийн асуудлыг энхийн аргаар шийдвэрлэхэд саад бэрхшээл

учруулж байна. Монгол-Оросын хил дээр ялангуяа Тыва, түүнтэй хил залган оршдог манай Хөвсгөл, Завхан, Увс аймгуудын чиглэлд тивэгтэй байдал цөөн биш гарлаа. Энэ чиглэлд зөвхөн 2006-2015 оны хооронд зэвсэг хэрэглэсэн тохиолдол Монголын талаас 52 удаа, Оросын талаас 47 удаа гарсан байна. Үүнээс үүдэн 17 хүн амь насаа алдсаны дотор 54 хувь нь Оросын талд, 46 хувь нь Монголын талд оногдож байгаа бөгөөд 16 хүн шархдаж гэмтэл авчээ.

Улсын хил дээр зэвсэг хэрэглэх болсон явдлын уршгийн ихэнх нь малын хулгайтай тэмцэх үед тохиолдож байжээ. Энэ үйлдэл нь улсын хилийн дархан байдлыг зөрчсөн гэмт хэргээс үүдэлтэй, тэдний эсрэг авч явуулсан ажиллагаа хууль ёсны арга хэмжээ боловч хилийн аюулгүй байдал, улсын хил, түүний орчимд хангагдах таатай нөхцлийг баталгаатай бодирдүүлэх үүднээс авч үзвэл түүрийн бодлогын түвшинд анхаарч, арга хэмжээ авах талаар тодорхой бодлого хэрэгтэй байна.

Монгол Улсын хил орчмын нутаг дэвсгэрийн ашигт малтмалын нөөцийг зохистой ашиглах бодлого баримтлах нь хил хязгаар нутгийг хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэх боловч замбараагүй олгогдсон ашигт малтмалын хайгуул болон ашиглалтын тусгай зөвшөөрөл /лиценз/ дотоодын аюулгүй байдалд түдийгүй тусгаар тогтнол, хил хязгаар, нутаг дэвсгэрийн халдашгүй, бүрэн бүтэн байдалд сэв суулгаж болзошгүй хүчин зүйл болоод байна.

Үүнөөдийн байдлаар Монгол Улсын хил орчмын 12 аймгийн нутаг дэвсгэрт нийт 133 аж ахуйн нэгж, ашигт малтмалын хайгуул, олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаагийн 82 нь хилийн бөсөд, 51 нь хилийн зурваст байна.

Ашигт малтмалын газраас ашигт малтмалын хайгуул болон ашиглалтын тусгай зөвшөөрөл /лиценз/ олгохдоо хууль зөрчиж олгодог нь дээрх зургаас харагдаж байна. Тухайлбал: Газрын тухай хуулийн 16-үйлд зааснаар **“Улсын хилийн зурвас газар”** нь Монгол Улс тусгай хэрэгцээний газарт хамаарна. Ашигт малтмалын тухай хуулийн 4-үйлд эрх бүхий байгууллага улсын болон орон нутгийн тусгай хэрэгцээний газарт **ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хязгаарласан, хориглосон** заалт бий.

Гэтэл үүнүүдэр хилийн зурваст Ашигт малтмалын газраас олгогдсон ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй 51 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна. Мөн үүнийг дагаж орон нутгийн иргэд хилийн бөс, зурваст хууль бусаар алт олборлох зөрчил багагүй нөлөөтэй байна. Тухайлбал энэ зорилгоор Хөвсгөл, Өмнөговь, Говь-Алтай, Дорноговь, Булган, Дорнод, Ховд аймгуудын хил орчмын сумын нутаг дэвсгэрт 2015 онд 21 удаа 2469 хүн зөрчил гаргаж байсан.

Нэгдрийн байдлаар гадаад, дотоодын баяжих, ашиг хонжоо олох шуналдаа хэтлэгдсэн гэмт хэрэгтэнд хараа хяналт, эзэмшлгүй болсон хил хязгаар нутгийн байгалийн баялагийг дур зоргоороо устган, гэмт хэргээ халхлахын тулд заримдаа гал тиймэр тавих, тэднийг саатуулсан хилчдийг эсэргүүцэх зэргээр зэрлэг догшин хандаж байна. Тэд гэмт хэрэг үйлдэхдээ улсын дархан хилийг хууль бусаар нэвтрэх, зорчих нь цогцгүй. Зөвхөн 1998-2015 онд гадаад дотоодоос Монгол, Хятадын хилийг 2176 удаа 6597 хүн зорчсон бол. Монгол, Оросын хилийг 3024 удаа 6394 хүн зорчжээ. Бүх зорчлийн 50%-ийг дотоодоос буюу Монголын талаас гаргаж байгаагийн дотор зарим аймагт 80 гаруй хувийг орон нутагт оршин суугчид үйлдсэн тооцоо гарсан байна.

Улсын хилийн аюулгүй байдлыг хүндэтгэн дээдлэх ёстой орон нутгийн оршин суугчидын эх орон, хил хязгаараа гэсэн сэтгэлийн тэнхээ хомсдож, тэр бүхнийг газар дээр нь, ойр орчмоос нөлүүлж удирдах төрийн төлөөлөл, чадвартай засаглал сулдаж байгаатай холбон зэх үндэс бий гэж үзэж байна. Малыг хариулах, бод малыг хотлуулах буюу манах хамгаалахад хайхрамжгүй хандаж байгаа явдал цогцгүй байгаагаас 1995 оноос 2015 оныг оруулаад 20 жилийн хугацаанд эзэн, хариулагчийгээс бэлчээрээр хил давж болзошгүй, хилд тулж очсон 263267 толгой малыг хилчид эргүүлэн татаж холбогдох эзэн, байгууллагад тушаажээ. Үүнээс дүгнэлт хийж үзвэл хил орчимд төр, нийгэм, иргэний язгуур эрх ашиг бүрэн хангагдаагүй бөгөөд төнд дотоодын хүчин зүйл ихээр нөлүүлж байна. Монгол Улсын татварын болон гаалийн бодлогоос хилийн зорчил ихээхэн хамаарч байгаа нь төхөн уламжлал болон зах зээлийн нийгэмд шилжсэн үнэт өөд тод мэдрэгдэж хилийн орон зайд МУ-ын аюулгүй байдал, язгуур ашиг сонирхолыг хурцаар хүндэж “хил хаалттай” байх тусам сүргээгээс (спирт, ноолуур, алт, автомашин, химийн хорт бодис сэм нэвтрүүлэх, малын хулгай, дээрэм зэрэг) ихээр гарч байгаагаар нотлогдож байна.

Өөрөөр хэлбэл улсын хилээр эд зүйл нэвтрүүлэх журам буюу экспорт, импортын бараа бүтээгдэхүүнд тодорхой хэмжээний хязгаар тавих, гаалийн татварыг нэмэгдүүлэх зэргээр гаргасан улс төрийн шийдвэр нь үндэсний ашиг сонирхолыг хангах зорилготой байдаг нь мэдээжийн хэрэг. Гэтэл энэхүү байдал нь эргээд хилийн аюулгүй байдалд сүргээр нөлүүлэх хүчин зүйлийг бий болгодог. Тухайлбал, Орон нутгийн ард иргэд 1кг махыг хүрш улсын хязгаарын ард иргэдэд зах зээлээс 3 дахин илүү үнээр борлуулах бололцоотой байна.

Энэ байдал нь эргээд улсын хилээр хориглосон болон хязгаарласан бараа, эд зүйл хууль бусаар нэвтрүүлэх зорилгоор үйлдэгдэх хилийн зөрчил нэмэгдэх шалтгаан нөхцөл болдог.

Мөн төмөрчлэн улсын хил нэвтрүүлэх талаар гарсан улс төрийн шийдвэрийг эсэргүүцсэн иргэд хилийн боомтод хил хяналтын байгууллагуудын үйл ажиллагаа болон боомтоор нэвтрэх хөндлөнгөөд саад учруулах зэргээр эмх замбараагүй байдал үүсгэдэг. Тухайлбал, Замын-Ордийн хилийн боомтоор суудлын автомашинаар хүн тээвэрлэх явдлыг хориглосон шийдвэрийг Засгийн газраас гаргаснаар тухайн боомтын хэсэгт хэв журам алдагдахад хүргэж байсан. Энэхүү байдал даамжирбал хил орчмын нутаг дэвсгэр, хилийн боомт газарт эмх замбараагүй байдал үүсгэдэг тул хилтэй холбогдсон асуудлаар шийдвэр гаргахад судалгаа, шинжилгээнд тулгуурлаж, сөрөг үр дагаврыг сайтар тооцсоны үндсэн дээр гаргах нь практик ач холбогдолтойг дээрх жишээнээс харж болно. Цаашид дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

1. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулан хилийн бүс, зурвасын эзэмшлийг сайжруулж, хил орчмын нутаг дэвсгэрийн хөгжлийн талаар нийгэм, эдийн засгийн цогцолбор арга хэмжээ авах. Хил дамнасан гэмт хэрэгтэй тэмцэх, хилийн боомт газарт эмх замбараагүй байдал үүсэх болон байгалийн гамшиг, хүн малын гоц халдварт үвчин тархахаас урьдчилан сэргийлэх, хил орчмын нутаг дэвсгэрт хөмүүлэхийн болон экологийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр хил залгаа болон бусад орнуудтай хамтын ажиллагааг бэхжүүлэх нь чухал төдийгүй цагийн байдал өссөн үед үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий байгууллага хамтран ажиллах оператив-тактикийн сургууль, дадлагыг зохион байгуулах нь болзошгүй ажиллагаанд бэлэн байхын үндэс болно.

2. Улсын хилийн бүс, зурвас, боомт газар орчин үеийн шаардлагад нийцсэн холбоо, хяналт дохиолол, зам, тээвэр, инженерийн байгууламж бүхий хил хамгаалалтын дэд бүтцийг хөгжүүлэх. Үүний тулд дэд бүтэц, барилга байгууламж бүхий хилийн хяналт шалгалт явуулах нөхцлийг хангасан хилийн боомтуудыг ажиллуулах, тэдгээрийн үйл ажиллагааг боловсронгуй болгож, орчин үеийн техник хэрэгсэл нэвтрүүлж зорчигч, тээврийн хэрэгсэл, бараа таваарын нэвтрүүлэлтийг олон улсын жишигт нийцүүлэх шаардлагатай.

3. Хил орчмын оршин суугчдаас хил хамгаалалтад оролцох явдлыг хөгжүүлэн дэмжих, урамшуулах, хил орчмын нутаг дэвсгэрт тогтвортой суурьших нөхцлийг бүрдүүлэх явдал чухал юм.